



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сантмаргац сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/71/СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayag@audit.gov.mn Аудитор:Ц.Алтантуул Утас: 91195554 Цахим хаяг : tuul9565@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.09.25 № 1802/20
танай _____ -ны № _____ -т

САНТМАРГАЦ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Р.АНХТУЯА-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сантмаргац сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сантмаргац сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

16.200,0 мянган төгрөгийн хөрөнгө зөвшөөрөлгүй олж бэлтгэсэн, 5.040,0 мянган төгрөгийн туслах аж ахуйтай холбоотой зардлыг үндсэн үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлсэн зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 44.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.2, 77.3 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013823064

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	55,594.99	59,327.26
35	БАРАА МАТЕРИАЛ	55,594.99	59,327.26
351	Түүхий эд материал	4,060.05	5,625.05
35110	Тусгай зориулалттай материал	3,321.55	5,154.55
35130	Эм боох материал	738.50	470.50
354	Хангамжийн материал	41,514.94	42,022.21
35410	Бичиг хэргийн материал	4,823.35	4,113.35
35420	Аж ахуйн материал	8,926.70	8,659.70
35440	Түлш, шатах тослох материал	1,420.00	1,955.00
35450	Барилгын засварын материал	2,476.41	1,906.81
35460	Хүнсний материал	6,581.40	7,343.87
35470	Бусад хангамжийн материал	17,287.08	18,043.48
35600	Мал амьтад	10,020.00	11,680.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,039,189.19	3,967,842.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,039,189.19	3,967,842.39
392	Биет хөрөнгө	4,009,333.69	3,938,234.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,177,734.35	4,177,734.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	(279,961.66)	(345,676.53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	155,770.69	148,232.59
39206	Хуримтлагдсан элэгдэл	(122,210.11)	(124,805.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,647.87	118,847.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,337.15)	(74,703.47)
39214	Бусад үндсэн хөрөнгө	58,110.60	58,110.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(32,151.95)	(35,434.74)
39217	Ном	15,731.05	15,929.35
393	Биет бус хөрөнгө	29,855.50	29,608.00
39301	Програм хангамж	2,400.00	2,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(942.50)	(1,190.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	28,398.00	28,398.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,094,784.18	4,027,169.65
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,094,784.18	4,027,169.65
51	Засгийн газрын хувь оролцоо	4,094,784.18	4,027,169.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	381,040.78	381,040.78
51101	Өмч: - төрийн	381,040.78	381,040.78
512	Хуримтлагдсан үр дүн	3,193,624.07	3,126,009.53
51210	Өмнөх үеийн үр дүн	3,193,624.07	3,193,624.07
51220	Тайлант үеийн үр дүн	-00	(67,614.53)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	520,119.34	520,119.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,094,784.18	4,027,169.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,578,785.55	1,020,945.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,657,806.96	22,049.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,657,806.96	22,049.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,657,806.96	22,049.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	965.61	18,759.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,656,841.35	3,290.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	920,978.59	998,896.81
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	774,491.94	776,111.31
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	774,491.94	776,111.31
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	146,486.65	222,785.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	146,486.65	222,785.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,208,041.66	1,086,930.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,208,041.66	1,086,930.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,155,309.40	1,046,600.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	604,515.24	586,541.66
210101	Үндсэн цалин	556,690.34	537,856.35
210104	Урамшуулал	47,824.90	48,685.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,278.90	82,334.28
210201	Тэтгэврийн даатгал	51,188.37	59,196.02
210202	Тэтгэмжийн даатгал	7,661.76	5,855.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,823.02	4,662.69
210204	Ажилгүйдлийн даатгал	1,145.98	1,146.38
210205	Эрүүл мэндийн даатгал	11,459.77	11,473.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,065.99	249,414.19
210301	Гэрэл, цахилгаан	2,934.18	7,880.89
210302	Түлш, халаалт	141,091.81	241,433.29
210303	Цэвэр, бохир ус	40.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,070.09	11,742.85
210401	Бичиг хэрэг	2,352.89	1,998.85
210402	Тээвэр, шатахуун	6,863.90	4,539.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	895.30	800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,507.10	4,404.60
2105	Нормативт зардал	14,987.29	19,816.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	490.30	1,268.00
210502	Хоол, хүнс	14,496.99	18,170.72
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-00	378.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,149.61	4,128.60
210604	Урсгал засвар	1,149.61	4,128.60
2107	Томилолт, зочны зардал	1,634.00	1,557.10
210702	Дотоод албан томилолт	1,634.00	1,557.10

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	579.10	800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-00	800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	299,029.17	90,265.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,855.80	2,520.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	295,173.37	87,745.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,732.26	40,329.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,400.94	39,754.15
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,680.00	22,048.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,220.94	17,206.15
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.00	500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,331.32	575.30
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	0	0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,331.32	575.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,370,743.89	(65,984.53)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	715.00	1,630.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	715.00	1,630.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(715.00)	(1,630.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,370,028.89	(67,614.53)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-00	-00	-00	-00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-00	-00	-00	-00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-00	-00	-00	-00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-00	-00	-00	-00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-00	-00	-00	-00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-00	-00	-00	-00
C07	Тайлант үеийн үр дүн	-00	-00	-00	-00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	381,040.78	520,119.34	3,193,624.07	4,094,784.18
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	381,040.78	520,119.34	3,193,624.07	4,094,784.18
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-00	-00	-00	-00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	381,040.78	520,119.34	3,193,624.07	4,094,784.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-00	-00	-00	-00

D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-00	-00	-00	-00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-00	-00	-00	-00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-00	-00	-00	-00
D08	Тайлант үеийн үр дүн	-00	-00	(67,614.53)	(67,614.53)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	381,040.78	520,119.34	3,126,009.53	4,027,169.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	527,094.59	1,017,655.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-00	18,759.00
120	Нийтлэг татварын бус орлого	-00	18,759.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-00	18,759.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-00	18,759.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	527,094.59	998,896.81
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	474,934.04	776,111.31
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	474,934.04	776,111.31
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,160.55	222,785.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,160.55	222,785.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	446,461.51	1,001,257.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	446,461.51	1,001,257.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	436,782.57	960,928.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,379.91	586,541.66
210101	Үндсэн цалин	348,379.91	537,856.35
210104	Урамшуулал	-00	48,685.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,100.25	82,334.28
210201	Тэтгэврийн даатгал	18,313.34	59,196.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,635.89	5,855.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,700.06	4,662.69
210204	Ажилгүйдлийн даатгал	1,112.32	1,146.38
210205	Эрүүл мэндийн даатгал	6,338.64	11,473.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,399.76	249,949.19
210301	Гэрэл, цахилгаан	2,071.29	7,880.89
210302	Түлш, халаалт	44,288.46	241,968.29
210303	Цэвэр, бохир ус	40.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,418.85	10,765.85
210401	Бичиг хэрэг	429.40	1,288.85
210402	Тээвэр, шатахуун	2,269.25	4,539.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	394.00	800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	276.20	4,137.60
2105	Нормативт зардал	3,683.10	21,067.59

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14.00	1,000.00
210502	Хоол, хүнс	2,034.70	18,933.19
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,634.40	1,134.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-00	3,559.00
210604	Урсгал засвар	-00	3,559.00
2107	Томилолт, зочны зардал	554.00	1,557.10
210702	Дотоод албан томилолт	554.00	1,557.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	579.10	800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-00	800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,667.60	4,353.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,667.60	4,353.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,678.94	40,329.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,678.94	39,754.15
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,458.00	22,048.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,220.94	17,206.15
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-00	500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-00	575.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-00	575.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	80,633.08	16,398.30
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,835.00	16,398.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,835.00	16,398.30
2200	Дотоод эх үүсвэрээр	1,835.00	16,398.30
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,835.00	16,398.30
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,835.00)	(16,398.30)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗ ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	926,908.90	980,589.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	926,908.90	980,589.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	910,914.90	958,041.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	579,083.40	586,541.66
210101	Үндсэн цалин	398,491.00	537,856.35
210104	Урамшуулал	31,217.70	48,685.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,176.10	82,334.28
210201	Тэтгэврийн даатгал	55,012.70	59,196.02
210202	Тэтгэмжийн даатгал	5,790.90	5,855.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,632.80	4,662.69
210204	Ажилгүйдлийн даатгал	1,158.10	1,146.38
210205	Эрүүл мэндийн даатгал	11,581.60	11,473.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,725.50	249,949.19

210301	Гэрэл, цахилгаан	7,762.50	7,880.89
210302	Түлш, халаалт	213,062.80	241,968.29
210303	Цэвэр, бохир ус	900.20	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,787.50	10,787.50
210401	Бичиг хэрэг	1,112.20	1,112.20
210402	Тээвэр, шатахуун	6,584.20	4,539.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800.00	800.00
210404	Ном, хэвлэл	1,668.30	198.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	622.80	4,137.60
2105	Нормативт зардал	13,781.40	21,067.59
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000.00	1,000.00
210502	Хоол, хүнс	11,647.00	18,933.19
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,134.40	1,134.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000.00	1,000.00
210604	Урсгал засвар	1,000.00	1,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,557.10	1,557.10
210702	Дотоод албан томилолт	1,557.10	1,557.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800.00	800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800.00	800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4.00	4.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,003.90	4,003.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15.99	22.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,994.00	22,548.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,494.00	22,048.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500.00	500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	926,908.90	981,164.50
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	704,183.40	758,379.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	704,183.40	758,379.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	222,725.50	222,785.50
132001	Орон нутгийн төсвөөс	222,725.50	222,785.50
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.05	0.05
620001	Удирдах ажилтан	0.00	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	0.03	0.03
620003	Үйлчлэх ажилтан	0.02	0.02

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		36,491.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ		36,491.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		19,285.15
2104	Хангамж, бараа материалын зардал		16,376.65
210401	Бичиг хэрэг		176.65
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		16,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,559.00

210604	Урсгал засвар		2,559.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-00	0.35
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		349.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-00	17.21
2132	Бусад урсгал шилжүүлэг		17,206.15
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		17,206.15

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сантмаргац сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Интер Аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Сантмаргац сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сантмаргац сумын Ерөнхий боловсролын сургууль нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сантмаргац сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1,086.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 16.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр	Тайлант оны эхний үлдэгдэл	Тайлант оны эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	55,594.99	59,327.26	3,732.27
2	БАРАА МАТЕРИАЛ	55,594.99	59,327.26	3,732.27
4	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,039,189.19	3,967,842.39	(71,346.80)
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,094,784.18	4,027,169.65	(67,614.53)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,094,784.18	4,027,169.65	(67,614.53)

Бараа материалын данс 3,732.2 мянган төгрөгөөр өссөн нь цаг үеийн шаардлагаар мах худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 71,346.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд хөрөнгө данснаас хассан мөн тайлант хугацааны элэгдлийн зардал өндөр тооцогдсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 67,614.53 мянган төгрөгөөр болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 981,164.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 981,164.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 758,379.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 222,785.5 мянган төгрөгийн нийт 981,164.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 980,589.2 мянган төгрөгийг зарцуулж, 575.3 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 36,491.3 мянган төгрөгийн нэмэлтийн орлого бүрдүүлэн, 17,206.1 мянган төгрөгийг хөдөө орон нутагт ажилласан багшийн тэтгэмжид, 16,200.0 мянган төгрөгийг үндсэн хөрөнгө бэлтгэхэд, 3,085.2 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.8 Аудитын гол асуудал

Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зардал гаргасан нь төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэр аудит хийгдсэн бөгөөд зөвлөмж өгөгдөөгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагад ашиглагдаж байгаа хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21.2 сая төгрөгийн 2 албан шаардлага, 0.3 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4.1 Залруулсан алдаа

4.2 Төлбөрийн акт

Мал амьтад данснаас 11 толгой 0.3 сая төгрөгийн ямаа дутагдсныг хариуцсан этгээдээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

- Үндсэн цалингаас 5.0 сая төгрөгөөр малчин цалинжуулсан нь Төсвийн тухай хуулийн 44.3 дугаар заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.
- Зөвшөөрөлгүй 16.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Засгийн газрын 43-р тогтоолыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгуул-лагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Сантмаргац сумын Ерөнхий боловсролын сургууль	3	21.5			1	0.3	2	21.2		